

**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН “ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖИЛ-НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ”
ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ
/2017.01.01-2017.09.29/**

Улаанбаатар хот

2017.09.29

№	Хөтөлбөрийн зорилт	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа		Биелэлт	Хувь	Хариуцах хэлтэс
1.1	Хүний нөөцийн менежментийг боловсронгуй болгох	1	Байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, Хүний нөөцийн нэгдсэн сан бий болгох.	Байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, Хүний нөөцийн нэгдсэн сан бий болгох ажлын хүрээнд “Хүний нөөцийн удирдлага, цаг бүртгэлийн удирдлага” нэгдсэн системийг 2017 оны 1 дүгээр сараас нэвтрүүлж ажилтан албан хаагчдын бүртгэл, судалгааг бүртгэлжүүлэн ажиллаж байна.	100	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс
		2	Холбогдох дээд шатны байгууллагаас баталсан бүтэц, орон тоогоор бүтцийг батлуулж мөрдөн ажиллана.	Нийслэлийн Засаг даргын 2016 оны “Дүүргийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, ажлын байрны үлгэрчилсэн жагсаалт батлах тухай” А/832 дугаар захирамжийн дагуу дүүргийн Засаг даргын 2017 оны 05 дугаар захирамжаар “Дүүргийн удирдлага, Засаг даргын Тамгын газрын бүтэц” орон тооны хязгаарт багтаан дүүргийн удирдлага, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллага, Засаг даргын Тамгын газрын бүтэц, ажлын байрын жагсаалтыг баталж, батлагдсан бүтэц орон тоо, зохион байгуулалтын дагуу Засаг даргын Тамгын газарт төрийн захиргааны 50 албан хаагч, төрийн тусгай 6 албан хаагч, төрийн үйлчилгээний 22 ажилтан, албан хаагч мөн анхан шатны нэгж хороонд Засаг дарга 19, Зохион байгуулагч 25, Нийгмийн ажилтан 19, туслах ажилтан 24, хэсгийн ахлагчаар 196 хүн ажиллаж байна.	100	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс

		3	<p>Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд байгууллагад ажиллаж байгаа буюу төрийн холбогдох бусад байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдаас үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингээр нь сонгон шалгаруулах замаар уг орон тоог нөхнө.</p>	<p>Монгол Улсын Их Хурлын 2003 оны “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын хүрээнд Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадын удирдах 2 /хоёр/ албан тушаалын сул орон тоо гарсантай холбогдуулан Монгол Улсын Их Хурлын 2003 оны “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14./а/-д заасныг үндэслэн төрийн байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдаас сонгон шалгаруулах хүсэлтийг Нийслэл дэх төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд хүргүүлсэн. Мөн дүүргийн Засаг даргын Тамгын газрын Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн Байгаль орчин, ногоон байгууламж харуицсан мэргэжилтнийг сонгон шалгаруулах хүсэлтийг Нийслэл дэх төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд хүргүүлж тус албан тушаалд сонгон шалгаруулалт зарлан, Нийслэл дэх төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн 1 иргэнийг холбогдох албан тушаалд томилж сул орон тоог нөхөх ажлыг хууль, тогтоомжийн хүрээнд зохион байгуулсан.</p>	90	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс
		4	<p>Төрийн жинхэнэ албаны удирдах болон анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэгдсэн, тухайн ажлын байранд тавигдах ерөнхий болон тусгай шаардлагыг хангаж байгаа иргэдийг томилуулахаар Нийслэл дэх төрийн албаны салбар зөвлөлд нэр дэвшүүлж,</p>	<p>Засаг даргын Тамгын газар, дэргэдэх харьяа хэлтэс, алба, хороодын төрийн захиргааны албан тушаалын сул орон тоонд тухайн ажлын байранд тавигдах ерөнхий болон тусгай шаардлагыг хангаж байгаа төрийн жинхэнэ албан тушаалд орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэлтэй иргэдээс сонгон шалгаруулан Нийслэл дэх төрийн албаны салбар зөвлөлд нэр дэвшүүлж, дүгнэлтийн дагуу 12 албан хаагчийг томилж, сул орон тоог нөхөх ажлыг холбогдох хууль, журмын хүрээнд зохион байгууллаа. Мөн 2017 оны 7 дугаар сард 9 ажлын байранд иргэний нөөцийн жагсаалтад бүртгэлтэй иргэдээс сонгон шалгаруулж нэр</p>	90	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс

			дүгнэлтийн дагуу албан тушаалд томилно.	дэвшүүлэхээр Нийслэл дэх төрийн албаны салбар зөвлөлд саналыг хүргүүлээд байна.		
		6	Нутгийн захиргааны байгууллагын албан хаагчийн албан тушаалын чиг үүргийн хуваарилалтын байдал, ажлын давхардал байгаа эсэхэд хяналт шинжилгээ хийж, дүгнэлт гаргах, ажлын байрны тодорхойлолт шинээр боловсруулах үүрэг бүхий байнгын, орон тооны бус ажлын хэсгийг дүүргийн Засаг даргын Тамгын газарт байгуулж ажиллуулна.	Засаг даргын Тамгын газрын даргын 2017 оны А/04 дүгээр тушаалаар албан хаагчдын “Ажлын байр /албан тушаал/-ны тодорхойлолт”-ыг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийн байгуулж, Засаг даргын Тамгын газар болон хороодын төрийн захиргааны албан хаагч, хэсгийн ахлагч нарын 65 ажлын байр /албан тушаал/-ны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулан үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж, дүүргийн вэб сайтад “Ажлын байр /албан тушаал/-ны тодорхойлолт”-ыг байршуулсан бөгөөд албан хаагчид ажлын байрын тодорхойлолтын үндсэн зорилго, зорилт, чиг үүрэг, тавигдах ерөнхий шаардлагын хүрээнд албан үүргээ гүйцэтгэсэн.	100	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс
1.2	Ажилтан албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх замаар байгууллагын үйл ажиллагааны үр дүнг сайжруулах	1	Байгууллагын шийдвэрээр ажлаас чөлөөлөгдөхгүйгээр сурах, мэргэшлээ дээшлүүлэх сургалт курст хамрагдсан албан хаагчдад суралцсан хугацаанд нь албан тушаалын цалин хөлсийг олгож, сурах болоцоогоор хангаж дэмжлэг үзүүлнэ.	Засаг даргын Тамгын газар, хороодын ажилтан, албан хаагчдыг мэргэшүүлэх, сургах, хөгжүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах зорилгоор гадаадын магистрантурын сургалтад 1, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Удирдлагын академийн мэргэшүүлэх сургалтад 4, их дээд сургуулийн магистрантурын сургалтад 2 ажилтан, сертификаттай сургалтад 5 ажилтан суралцаж байгаа бөгөөд суралцах хугацаанд цалинтай чөлөө олгуулах ажлыг зохион байгуулж дэмжлэг үзүүлсэн	100	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс
		2	Хууль тогтоомж, эрх зүйн баримт бичиг, төрийн захиргааны шинэчлэл, стандартын талаар холбогдох мэргэжлийн байгууллагуутай хамтран сургалт	“Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах санал асуулгын талаарх хэлэлцүүлэг”, “Харилцааны соёлыг дадал болгох”, “Албан хэрэг хөтлөлтийн дотоод системийн үйл ажиллагаа” сэдэвт чадавхжуулах 3 удаагийн сургалтад Тамгын газрын албан хаагчдыг хамруулсан.	30	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс

			зохион байгуулна.			
		3	Дүүргийн Засаг даргын Тамгын газрын ижил чиг үүрэгтэй гадаадын байгууллагуудтай хамтран ажиллах, ажилтнуудыг харилцан туршлага судлуулах ажлыг зохион байгуулна.	Дүүргийн Тамгын газрын Гадаад, дотоодын харилцаа, хамтын ажиллагааны хүрээнд төрийн албан хаагчдыг мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх чиглэлийн бодлого баримтлан ажиллаж байна. 2017 оны 9 дүгээр сард зохион байгуулсан БНСУ-ын Ёнсу дүүрэгтэй хамтын ажиллагааны хүрээнд Засаг даргын Орлогчоор ахлуулсан ЗДТГ-ын баг бүрэлдэхүүн тус дүүрэгт ажиллан холбогдох чиглэлээр санал солилцон, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагаанд тусган ажиллаж байна. Дотоодын хамтын ажиллагааны хүрээнд дүүргийн ЗДТГ-ын хэлтэс албадын дарга нарын бүрэлдэхүүн Архангай аймгийн Чулуут сумын ЗДТГ-т туршлага судлах цаашид хамтран ажиллах ажлыг зохион байгуулсан.	100	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс
		4	Төрийн захиргаа, төрийн албаны шинэчлэлтэй уялдуулсан шинэ мэдлэг мэдээллээр тасралтгүй хангах ажлыг зохион байгуулах, мэдээллийн цагийг тогтмол зохион байгуулах	Монгол Улсын Засгийн газрын 1999 оны “Төрийн албаны сургалт ба мэдлэг чадвар бий болгох хөтөлбөр” батлах тухай 96 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Засаг даргын Тамгын газар болон хороодын ажилтан, албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх, хөгжүүлэх, мэдээлэл солилцох зорилгоор “Мэдээллийн цаг сургалт”-ыг 8 удаа зохион байгуулсан.	70	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс
		5	Төрийн албан хаагчдын ёс зүй, харилцааны асуудалд анхаарч, тэдэнд харилцааны соёл эзэмшүүлэх сургалтыг зохион байгуулах.	“Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах санал асуулгын талаарх хэлэлцүүлэг”, “Харилцааны соёлыг дадал болгох”, “Албан хэрэг хөтлөлтийн дотоод системийн үйл ажиллагаа” сэдэвт чадавхжуулах 3 удаагийн сургалтад Тамгын газрын албан хаагчдыг хамруулсан.	70	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс

1.3	Албан хаагчдыг үр бүтээлтэй, тогтвор суурьшилтай ажиллуулах	1	Үр дүнгийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж, “Маш сайн” болон “Сайн” үнэлэгдсэн төрийн захиргааны албан хаагчдад холбогдох журмын хүрээнд мөнгөн урамшуулал олгоно.	Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоол буюу “Менежерийн болон төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журам”, “Төрийн жинхэнэ албан хаагчийн үр дүнгийн гэрээ байгуулах, гэрээний биелэлтийг дүгнэх аргачлал”-ын хүрээнд Засаг даргын Тамгын газрын дарга 7 хэлтсийн даргатай, хэлтсийн дарга нар Засаг даргын Тамгын газрын болон хороодын төрийн захиргааны 95 албан хаагч 2017 оны үйл ажиллагааны үр дүнгийн гэрээ байгуулж, ажлын үр дүнг хагас жилээр тооцуулан ажиллаа.	100	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс
		2	Жил бүрийн 1 дүгээр улиралд ажилтан, албан хаагчдаас ээлжийн амралтын хуваарийн саналыг авч, Тамгын газрын даргын тушаалаар ээлжийн амралтын хуваарийг батлуулж, ээлжийн амралтын олговрыг тухай бүр олгоно.	Дүүргийн Засаг даргын Тамгын газар, хороодын ажилтан, албан хаагчдын 2017 оны ээлжийн амралтын хуваарийг Тамгын газрын даргын Б/95 дугаар тушаалаар батлуулан ажилтан, албан хаагчдыг хуваарийн дагуу ээлжийн амралтыг олгоод байна.	100	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс
	Хувь хүний хөгжил-суралцагч байгууллагын харилцан хамаарал, Сургалт хөгжил	1	Шинэ ажилтан, албан хаагчдыг ажлын байранд сургаж, дадлагажуулах	“Хүний нөөцийн хөгжил, нийгмийн баталгааг хангах” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллах ажлын хүрээнд дүүргийн Засаг даргын Тамгын газар болон хороодод ажиллахаар шинээр томилогдсон ажилтан албан хаагчдад дүүргийн нийгэм, эдийн засгийн зорилт, үйл ажиллагааны хөтөлбөрийн талаар мэдлэг олгох, байгууллагын бодлого, төлөвлөлт, бүтэц, зохион байгуулалт болон холбогдох дүрэм, журмыг танилцуулах, ажиллах таатай орчныг бүрдүүлэх, хүний нөөцийн бодлогын ил тод нээлттэй байдлыг хангах, ажиллах чадварыг өндөржүүлэх, хамт олныг төлөвшүүлэхэд зорилт тавин шинэ ажилтны сургалтын хөтөлбөрийг боловсруулан 2017 оны	70	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс

			10 дугаар сард зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.			
2.1	Ажиллах орныг бүрдүүлэх	1	Төрийн албан хаагчдын ажиллах таатай орчин нөхцөлийг бүрдүүлэн өрөө, тасалгаа, танхимыг үе шаттайгаар засч тохижуулна.	Ажилтан, албан хаагчдын ажиллах орчныг сайжруулах, таатай орчныг бүрдүүлэх зорилгоор урсгал засварын ажлыг хийж, Засаг даргын Тамгын газрын болон хороодын байр, өрөө, тасалгаанд тавилга худалдан авахад 110.719.265 төгрөг зарцуулсан. Тус ажилд Тамгын газрын 2 давхарын ТЗУХ, ХБТХАХ-н ерөөний засвар, 5 давхарын иж бүрэн засварын ажил, уулзалтын танхим, Мэдээлэл технологийн нэгдсэн удирдлагын өрөө зэрэг засвар үйлчилгээг бүрэн хийж гүйцэтгэлээ.	100	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс
		2	Ажилтан, албан хаагчдыг ажиллах нөхцөл бололцоогоор хангаж шаардлагатай техник хэрэгслээр ханган ажиллана.	2017 онд техник хэрэгсэл шинэчлэх ажлын хүрээнд 16 компьютер, 2 принтер, 1 скайнер, Мэдээлэл технологийн албанд мэргэжлийн камер 1, архивт хадгалах төхөөрөмжийг албан хаагчдын албан хэрэгцээнд шинэчлэх ажлыг хийж хэрэгжүүллээ. Тоног төхөөрөмж, техник хэрэгсэл худалдан авахад 50.000.000 төгрөг зарцуулсан. 2017 оны 4 дүгээр улиралд Архив, бичиг хэргийн тасгийн үйл ажиллагаанд шаардагдах тоног төхөөрөмжөөр хангахаар төлөвлөн ажиллаж байна.	100	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс
		3	Албан хаагчдын хөдөлмөрийн бүтээмж, ажил үйлчилгээний чанарыг дээшлүүлэх, хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй нөхцөлийг хангаж ажиллана.	Албан хаагчдын хөдөлмөрийн бүтээмж, ажил үйлчилгээний чанарыг дээшлүүлэх ажлын хүрээнд Тамгын газрын 5 давхарт мэдээлэл технологийн суурь дэд бүтцийн өргөтгөлийн ажлыг хийсэн бөгөөд хороод дэргэдэх хэлтэс, албадтай видео хурал хийх боломжийг бүрдүүлэхээр зорилт тавин ажиллаж байна. Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй нөхцөлийг хангаж ажиллах ажлын хүрээнд дүүргийн Засаг даргын Тамгын газар албан хаагчдад анхан шатны эрүүл мэндийн тусламж, зөвлөгөө өгөх зорилгоор Тамгын газарт гэрээт эмч томилон	100	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс

				ажиллуулан анхан шатны тоног төхөөрөмжөөр тусгай өрөө тохижуулан ажиллалаа. Мөн ажлын байранд хөдөлмөрийн эрүүл ахуй, зөв дадлыг хэвшил болгох үүднээс холбогдох байгууллагуудаас “Мэдээллийн цаг” нэгдсэн сургалтаар мэдээлэл өгч ажиллалаа.		
2.2	Нийгмийн баталгааг хангах	1	Тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллаж байгаа албан хаагчдыг орон сууц, хашаа байшин худалдан авахад хөнгөлөлттэй зээлд хамруулах, санхүүгийн дэмжлэг тусалцаа үзүүлэх асуудлыг холбогдох дүрэм журмын хүрээнд шийдвэрлэнэ.	Тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллаж байгаа албан хаагчдыг орон сууц, хашаа байшин худалдан авахад хөнгөлөлттэй зээлд хамруулах, санхүүгийн дэмжлэг тусалцаа үзүүлэх, нийгмийн асуудлыг шийдвэрлэх ажлын хүрээнд 5 төрийн албан хаагчдад 17.800.684 /арван долоон сая найман зуун мянга зургаан зуун наян дөрөв/ төгрөгийн санхүүгийн бодит дэмжлэг, тусламж олгуулсан.	100	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс Дэргэдэх хэлтэс, албад
		2	Төрийн албан хаагчийн ойрын төрөл, садан нас барсан тохиолдолд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2-оос 3 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний мөнгөн тусламж үзүүлнэ	Төрийн албаны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.4.3 дахь заалт, Засгийн газрын 2004 оны “Журам батлах тухай 112 дугаар тогтоол, байгууллагын дотоод журмын хүрээнд Засаг даргын Тамгын газар, хороодын ажилтан албан хаагчдын гэр бүл, төрөл садангийн хүн нас барах, өвчний улмаас хөдөлмөрийн чадваргүй болсон гэр бүлийн гишүүнийг нь тэтгэхэд 6 албан хаагчид 5.700.000 /таван сая долоон зуун мянга/ төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж олгуулсан	100	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс
		3	Төрийн албан хаагч өөрөө эсвэл төрийн албан хаагчийн эхнэр нь амаржихад нэг сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тусламж олгоно.	Төрийн албан хаагчийн эхнэр нь амаржсан болон өөрөө амаржсан 5 албан хаагчдад нийт 2.590.021 /хоёр сая таван зуун ерэн мянга хорин нэг/ төгрөгийн тусламж олгуулсан	100	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс

2.3	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, чөлөөт цагийг зөв зохистой өнгөрүүлэх нөхцөл боломжоор хангах	1	<p>Төрийн албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор дүүргийн эрүүл мэндийн төв, бусад эрүүл мэндийн байгууллагатай хамтран Засаг даргын Тамгын газар болон хороодын ажилтнуудыг жилд тогтмол 1-ээс доошгүй удаа нарийн мэргэжлийн оношлогоо шинжилгээнд хамруулж, архаг өвчтэй ажилтнуудыг эмчийн болон эмнэлгийн хяналтанд авч рашаан сувилалд сувилуулах, эмнэлэгийн тусламж дэмжлэг үзүүлнэ.</p>	<p>Ажилтан, албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх, өвчлөлтийг эрт илрүүлэх зорилгоор нарийн мэргэжлийн эрүүл мэндийн үзлэг оношлогоо, шинжилгээнд хамруулах ажлыг “Сөүл сонгдо” эмнэлэгтэй хамтран нэг бүрийн 100.000 төгрөгийн нарийн мэргэжлийн багц оношлогоо шинжилгээнд нийт 166 ажилтан, албан хаагчдыг хамруулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулж, тус ажилд 16.600.000 төгрөгийг зарцуулсан.</p> <p>МУ-ын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал”-ыг хэрэгжүүлэх хүрээнд Монгол улсын Засгийн газрын 2017 оны 112 дугаар тогтоолоор батлагдсан “ЭЛЭГ БҮТЭН МОНГОЛ” хөтөлбөрийн хүрээнд дүүргийн Эрүүл мэндийн нэгдэлтэй хамтран нийт 78 40-с дээш насны албан хаагчдын элэгний Б, Ц вирусын шинжилгээнд хамруулсан.</p> <p>Дүүргийн Засаг даргын Тамгын газар албан хаагчдад анхан шатны эрүүл мэндийн тусламж, зөвлөгөө өгөх зорилгоор Тамгын газарт гэрээт эмч томилон ажиллуулан анхан шатны тоног төхөөрөмжөөр тусгай өрөө тохижуулан ажиллалаа.</p>	100	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс
		2	<p>Албан хаагчдын эрүүл мэнд чийрэгжилтэнд анхааран Биеийн тамир, спортын хорооны спортын заалыг ашиглан чөлөөт тоглолт хийх, уралдаан тэмцээн зохих зэрэг ажлуудыг зохион байгуулна.</p>	<p>Ажилтан, албан хаагчид 7 хоног бүрийн Баасан гарагийн 17.30-аас 21.00 цагийн хооронд дүүргийн Биеийн тамир, спорт хорооны зааланд чөлөөт цагаа өнгөрөөх нөхцөл бололцоогоор ханган ажиллаж байна.</p> <p>2017 онд Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах, албан хаагчдын бие бялдрыг чийрэгжүүлэх, нийтийн биеийн тамир, спортыг дэмжих зорилгоор төрийн ажилтан, албан хаагчдын дунд зохион байгуулагдсан “Спорт наадам 2017” тэмцээн уралдаанд баг хамт олноороо амжилттай оролцож 5 төрөлд</p>	100	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс

			медальт байр эзэлсэн.		
	3	Цасны баяр, явган болон тойрон аялалыг жилд 1-ээс доошгүй удаа зохион байгуулна.	“Монгол наадам цогцолбор”-т 2017 оны 01-р сарын 08-ны өдөр дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба, Засаг даргын Тамгын газрын албан хаагч, хороодын албан хаагчид хамтран цасны баярын арга хэмжээ зохион байгуулан ажилласан.	100	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс
	4	Ажилтан, албан хаагчдыг хамруулсан бүрэн хамруулсан болон хэсэгчлэн хуваан чөлөөт цагаараа хамт олноороо үзвэр үзэх, биеийн тамирын уралдаан тэмцээн, өдөрлөгийг жилд 2-оос доошгүй удаа зохион байгуулах нөхцөлийг бүрдүлнэ.	Ажилтан, албан хаагчид 7 хоног бүрийн Баасан гарагийн 17.30-аас 21.00 цагийн хооронд дүүргийн Биеийн тамир, спорт хорооны зааланд чөлөөт цагаа өнгөрөөх нөхцөл бололцоогоор ханган ажиллаж байна. 2017 онд Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах, албан хаагчдын бие бялдрыг чийрэгжүүлэх, нийтийн биеийн тамир, спортыг дэмжих зорилгоор төрийн ажилтан, албан хаагчдын дунд зохион байгуулагдсан “Спорт наадам 2017” тэмцээн уралдаанд баг хамт олноороо амжилттай оролцож 5 төрөлд медальт байр эзэлсэн.	100	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс
Биелэлт /хувиар %/				92.1	

Хянасан: Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга О.Нямбат

Биелэлт гаргасан: Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Хүний нөөц, ёс зүйн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Мөнхбаяр